



2024 оны 7 сарын 18-ны өдөр

№2024/45

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус
хурлыг зарлан хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1, 60.2, 60.4 дэх заалт, 62 дугаар зүйлийн 62.1.1, 62.1.9, 62.1.14 дэх заалт, 65 дугаар зүйлийн 65.1, 65.3, 65.4, 65.5, 65.6 дахь заалт, 67 дугаар зүйл, 71 дүгээр зүйлийн 71.1, 71.3 дахь хэсэг, Санхүүгийн Зохицуулах Хорооны 2018 оны 12 сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2024 оны 7 сарын 18-ны өдрийн шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Ард Кредит ББСБ” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал (цаашид “Хурал” гэх)-ыг 2024 оны 8 дугаар сарын 29-ний өдрийн 11 цагт цахим хэлбэрээр хуралдуулсугай.
2. Хурлыг зарлах тухай мэдэгдлийг 2024 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн дотор Санхүүгийн Зохицуулах Хороо, Монголын Хөрөнгийн Биржид тус тус хүргүүлсүгэй.
3. Хурал хуралдуулах тухай зар мэдээг Монголын Хөрөнгийн Биржийн цахим хуудас, өдөр тутмын хоёроос доошгүй сонин болон бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан 2024 оны 7 дугаар сарын 23-ны өдрийн дотор нийтэд мэдээлж, уг зарын давталтыг 2024 оны 8 дугаар сарын 07-ны өдөр анх зарласан хэлбэрээр дахин нийтэд мэдээлсүгэй.
4. Хуралд оролцох эрхтэй Хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2024 оны 8 дугаар сарын 09-ний өдрөөр тогтоосугай.
5. Хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт, гарах шийдвэрийн төсөл, танилцуулга, саналын хуудас зэрэг бусад холбоотой баримт бичгийг 2024 оны 7 дугаар сарын 23-ны өдөрт багтаан үнэт цаасны брокер, дилерийн компаниудад хүргүүлсүгэй.
6. Хурлын даргаар “Ард Кредит ББСБ” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга (Ч.Ганзориг)-ийг томилсугай.
7. Дараах нэр бүхий хүмүүсийг Хурал зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнээр томилсугай.

Үүнд:

Хурал зохион байгуулах комиссын дарга:

Гүйцэтгэх захирал Г.Сүхбаатар

Хурал зохион байгуулах комиссын гишүүд:

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Нарийн бичгийн дарга Г.Есү-Үжин

Санхүү эрхэлсэн захирал Д.Лхагва-Очир

Ерөнхий нягтлан бодогч Х.Цэрэннадмид

Туслах хуульч Г.Буянтогтох

8. Хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтыг нэгдүгээр хавсралтаар, саналын хуудасны загварыг хоёрдугаар хавсралтаар, Хурлын нийтэд хүргэх зарын загварыг гуравдугаар хавсралтаар,

Хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой материалын жагсаалтыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

9. Санал авах хуудсаар урьдчилж санал өгөх сүүлчийн хугацааг 2024 оны 8 дугаар сарын 27-ны өдрийн 18:00 цагаар тасалбар болгосугай.
10. Хувьцаа эзэмшигчдийг Хурлын материалтай танилцах нөхцөл, боломжийг бүрдүүлж ажиллахыг Хурал зохион байгуулах комисс (Г.Сүхбаатар)-т даалгасугай.
11. Хурлын Тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:
Тооллогын комиссын дарга: Ө.Бямбагэрэл (“Ард секюритиз” ҮЦК ХХК)
Тооллогын комиссын гишүүн: Т.Батбаяр (“Ард секюритиз” ҮЦК ХХК)
Тооллогын комиссын гишүүн: Ө.Март (“Ард Кредит ББСБ” ХК)
12. Холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хурлыг зарлан хуралдуулах, хурлын зар мэдээг хүргэх, хувьцаа эзэмшигчдийг шаардлагатай мэдээллээр хангаж ажиллахыг Хурал зохион байгуулах комисс (Г.Сүхбаатар)-д даалгасугай.
13. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар шийдвэрлэсэн асуудал болон бусад материалыг Компанийн тухай хууль болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан хугацаанд Монголын Хөрөнгийн Бирж, Санхүүгийн Зохицуулах Хороонд хүргүүлэхийг хурлын дарга (Ч.Ганзориг) болон Хурал зохион байгуулах комисс (Г.Сүхбаатар) нарт даалгасугай.

ДАРГА



Ч.ГАНЗОРИГ